



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 34 (511)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *"Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц"-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2007 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2007 оны есдүгээр сарын 14

№34 (511)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

429. "Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиулэн дэмжих тухай" 2005 оны ЮНЕСКО-гийн конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай 838
430. "Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг олон улсын конвенц"-д Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлах тухай 838

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

431. Зарим офицер, ахлагч нарыг медалиар шагнах тухай Дугаар 182 838
432. Суварга хайрхан уул, Хан хөхий уул, Сутай хайрхан уулыг төрийн тахилгатай болгох тухай Дугаар 183 843
433. Журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 184 843
434. Маньбадрахын Ганболдод дээд офицерийн цол хүртээх тухай Дугаар 185 844
435. Цэдэвийн Сэргэлэнд дээд офицерийн цол хүртээх тухай Дугаар 186 844
436. Халидолдагийн Жекейд дээд офицерийн цол хүртээх тухай Дугаар 187 844
437. Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 188 844
438. Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай Дугаар 189 845
439. Б.Нямсүрэнг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай Дугаар 190 845
440. Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 191 845
441. Дүрэм батлах тухай Дугаар 192 846
442. П.Бямбадоржийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 193 850
443. Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай Дугаар 194 850

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

444. Хөтөлбөр батлах тухай Дугаар 159 851
445. Засгийн газрын хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай Дугаар 160 857
446. "Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал" сэдэвт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай Дугаар 168 857
447. Тогтоолын заалт хүчингүй болгох тухай Дугаар 169 858
448. Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай Дугаар 170 858

449.	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	Дугаар 174	858
450.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 177	859
451.	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 181	859
452.	Зардлын дундаж норматив батлах тухай	Дугаар 184	859
453.	Нэрэмжит болгох тухай	Дугаар 189	861
453.	Байнгын төлөөлөгчийг томилох, эгүүлэн татах тухай	Дугаар 191	862
454.	Цагаан зээрийн эвэр, халиун бугын ясан эвэр гадаадад гаргахыг хориглох тухай	Дугаар 192	862
455.	Монголын бүх ард түмний спортын XII их наадам зохион байгуулах тухай	Дугаар 193	862
456.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 195	863
457.	Улсын нэгдсэн үзлэг, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Дугаар 201	863
458.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 212	864
459.	Хэлэлцээр батлах тухай	Дугаар 213	864

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

"СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЛИЙН ОЛОН ТӨРЛИЙГ ХАМГААЛАХ БОЛОН ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ТУХАЙ" 2005 ОНЫ ЮНЕСКО-ГИЙН КОНВЕНЦИД МОНГОЛ УЛС НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Францын Парис хотноо 2005 оны 10 дугаар сарын 25-ны өдөр баталсан "Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай" ЮНЕСКО-гийн Конвенцид

Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2007 оны 08 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

"СПОРТОД СЭРГЭЭШ ХЭРЭГЛЭХИЙН ЭСРЭГ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦ"-Д МОНГОЛ УЛС НЭГДЭН ОРСНЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нэгдсэн Үндэстний байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын 2005 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн Ерөнхий чуулганы 33 дугаар хуралдаанаар баталсан "Спортд сэргээш хэрэглэхийн эсрэг олон

улсын конвенц"-д Монгол Улс нэгдэн орсныг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Д. ЛҮНДЭЭЖАНЦАН**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 182

Улаанбаатар хот

**Зарим офицер, ахлагч нарыг
медалиар шагнах тухай**

Сьерра Леон Улс дахь НҮБ-ын Энхийг сахиулах хүмүүнлэгийн олон улсын цэргийн ажиллагаанд оролцож албан үүргээ нэр төртэй

биелүүлсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн дор дурдсан офицер, ахлагч нарыг медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Жамбаагийн Бадамбазар - БХЯ-ны Стратегийн удирдлага, төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, хурандаа
2. Гүрсэдийн Батсайхан - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
3. Дулмаагийн Баттулга - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн авто хуягт техник хэрэгсэл

4. Батжаргалын Отгонбаяр - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа
5. Намжилын Оюунсамбуу - Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн мэс заслын их эмч, ахмад

"ЭНХИЙН ТӨЛӨӨ" МЕДАЛИАР:

1. Наранцэцэгийн Алтанбагана - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн англи хэлний багш, сургагч ахлагч
2. Амарсайханы Алтангэрэл - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
3. Төмөрбаатарын Алтанхундага - Хилийн цэргийн 0243 дугаар ангийн заставын орлогч, ахлах дэслэгч
4. Пүрэвдоржийн Алтанхуяг - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
5. Цэцэгмаагийн Алтаншагай - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн оператор буудагч, дэд ахлагч
6. Ойдовын Амарсанаа - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
7. Гантулгын Амартүвшин - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
8. Ломбуудоржийн Амартүвшин - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн автын засварчин, дэд ахлагч
9. Доржлаламын Амгаланбаатар - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн пулемётчин, ахлах ахлагч
10. Пүрэвийн Анхбаяр - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн жолооч, ахлагч
11. Төртүвшингийн Ариунболд - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн тусгай холбооны мэргэжилтэн жолооч, ахлагч
12. Даваасамбуугийн Баасансүрэн - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн бууны дарга, дэд ахлагч
13. Бат-Өлзийн Баатарпүрэв - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик оператор, дэд ахлагч
14. Батсанаагийн Баднаанямбуу - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч
15. Адъяагийн Батаа - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн салааны захирагч, жолооч, ахлах ахлагч
16. Гочоосүрэнгийн Батбаяр - ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа
17. Лхагвасүрэнгийн Батбаяр - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн нярав засварчин, дэд ахлагч
18. Төгсийн Батбилэг - Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн механик жолооч, ахлагч

19. Довчингийн Батболд - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн агуулахын дарга жолооч, ахлах ахлагч
20. Жигжидийн Батболд - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нярав-засварчин, дэд ахлагч
21. Санжаагийн Батдорж - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн наводчик оператор, дэд ахлагч
22. Пүрэвбазарын Батжаргал - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн нууцын дарга, ахлах ахлагч
23. Халтарын Батжаргал - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн холбооны зангилгааны дарга, ахлах дэслэгч
24. Сүхээгийн Батзориг - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн химийн дарга, дэслэгч
25. Шагдарын Батзориг - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн сантехникийн инженер, дэслэгч
26. Далхаагийн Бат-Оргил - Зэвсэгт хүчний 330-р ангийн гранатомётчины туслах буудагч, дэд ахлагч
27. Нямсүрэнгийн Батсүрэн - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн зангилгааны дарга, хошууч
28. Чулуунхүүгийн Батсүх - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн механик жолооч, ахлагч
29. Пүрэвсүрэнгийн Батхүлэг - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн артиллерийн салааны тооцоочин, дэд ахлагч
30. Равдангийн Батням - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
31. Ухнаагийн Батцэнгэл - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн механик жолооч, ахлагч
32. Суранхүүгийн Бат-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
33. Батцоожийн Баяраа - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
34. Жүгдэрийн Баяраа - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлагч
35. Батсайханы Баярсайхан - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн бүлгийн дарга, ахлах дэслэгч
36. Чадраабалын Баярсайхан - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн механик жолооч, ахлах ахлагч
37. Шаарийбуугийн Билэгсайхан - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн гэрээт цэрэг, байлдагч

38. Буяннэмэхийн Буяндэлгэр - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн нярав засварчин, дэд ахлагч
39. Баднайхүүгийн Болдбаатар - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
40. Пүрэвжавын Болор-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн жолооч, сургагч ахлагч
41. Шинэжүүгийн Бэхбат - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн артиллерийн талнуулын салааны тооцоочин, дэд ахлагч
42. Эрдэнэтөгтохын Бямбадэлгэр - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн станцын дарга жолооч, ахлагч
43. Ганхүүгийн Бямбасэрж - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн артиллерийн салааны чиглүүлэгч, ахлагч
44. Дашзэвгийн Ваня - ЗХЖШ-ын Ар талын газрын Авто хуягт техникийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа
45. Цогтын Гаанжуржав - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ротын захирагчийн орлогч, ахлах дэслэгч
46. Доржийн Ганбаатар - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн засварын салааны тасгийн захирагч, жолооч, ахлах ахлагч
47. Донровын Ганбаатар - БХЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа
48. Хүрэлбаатарын Ганбаатар - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, дэд ахлагч
49. Чойжавын Ганбаатар - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн техник шалгах байрын дарга, ахлах ахлагч
50. Амарсайханы Ганбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн радио-телеграфчин, дэд ахлагч
51. Батжаргалын Ганбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч
52. Загдаагийн Ганбат - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн сургалтын процесс хангах ротын сургагч багш, сургагч ахлагч
53. Жадамбын Ганбат - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн тээврийн салааны жолооч, ахлах ахлагч
54. Шаалуугийн Ганбат - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн харуулчин, ахлагч
55. Санжаажамцын Ганбат - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн хөдөн бүлгийн ахлах засварчин, ахлах ахлагч
56. Дугарсүрэнгийн Ганболд - Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн дотрын кабинетын дарга, дэд хурандаа
57. Гүржавын Ганзориг - Дотоодын цэргийн хамгаалалтын салбарын харуулчин, ахлагч
58. Дамбын Ганзориг - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн гэрээт цэрэг, дэд түрүүч
59. Колчигийн Ганзориг - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
60. Ноовын Ганзориг - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн станцын дарга жолооч, ахлагч
61. Энхтайваны Ганзориг - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
62. Тогтуурын Гансүх - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн мэргэн буудагч, дэд ахлагч
63. Балдоржийн Гантөмөр - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тасгийн захирагч, ахлагч
64. Гэрэлчулууны Гантөр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн биеийн тамир, гардан тулааны багш, дэслэгч
65. Хорлоогийн Гантулга - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагчийн орлогч, ахлагч
66. Пүрэвдамбын Ганхуяг - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нярав засварчин, дэд ахлагч
67. Раднаабазарын Ганхуяг - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик оператор, дэд ахлагч
68. Батмөнхийн Гэрэлт-Од - Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн механик жолооч, дэд ахлагч
69. Бат-Эрдэнийн Гэрэлт-Од - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн ротын захирагч, дэслэгч
70. Лувсанцэрэнгийн Даваамягмар - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч
71. Дүүрэнжаргалын Далайцэрэн - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сумлагч, дэд ахлагч
72. Чулууны Дамдинсүрэн - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагч, ахлах дэслэгч
73. Хандаагийн Дорждэрэм - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн жолооч радио- телеграфчин, дэд ахлагч
74. Бибишийн Доржпалам - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн тасгийн пулемётчин, дэд ахлагч
75. Эрхбаялагийн Дэлгэрцог - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч
76. Маналын Дэмчиг - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн талнуулын дарга, хошууч
77. Жанчивын Жамбалнямбуу - Дотоодын цэргийн тусгай бэлтгэлтэй бүлгийн албан хаагч, ахлах ахлагч
78. Эрдэнэдаваагийн Жамъян - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн зэвсгийн нярав засварчин, дэд ахлагч
79. Дашцэдэнгийн Жигжидсүрэн - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа
80. Сэрдамбын Золжаргал - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн сургуулийн төвийн оператор, ахлах ахлагч
81. Сандуймаагийн Зэвэг - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн постын дарга, сургагч ахлагч
82. Буурайн Ишдорж - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нярав засварчин жолооч, ахлагч
83. Нацагдоржийн Лхагвацэрэн - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн механик жолооч-сургагч, ахлагч
84. Гантөмөрийн Майнбаяр - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч

85. Бямбатогтохын Машбаяр - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн химичин жолооч, дэд ахлагч
86. Цэвээн-Өөлдийн Мөнгөнцогт - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн мини тээслэгээний техникч, ахлах ахлагч
87. Борчулууны Мөнхбаатар - Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн тусгай холбооны мэргэжилтэн, дэд ахлагч
88. Цэдэвлүрэвийн Мөнхбат - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн механик жолооч-сургагч, ахлах ахлагч
89. Арсланбаатарын Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн жолооч радиотелеграфчин, дэд ахлагч
90. Жаргалсайханы Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нярав засварчин, дэд ахлагч
91. Рэгээгийн Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн жолооч, дэд ахлагч
92. Сүхбаатарын Мөнхболд - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
93. Цогтбаатарын Мөнхдалай - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
94. Дэжидмаагийн Мөнхдархан - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн кранчин жолооч, ахлагч
95. Пайлаагийн Мөнхжаргал - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн ротын жагсаалын дарга, ахлах ахлагч
96. Пүрэвсүрэнгийн Мөнхсүлд - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн жолооч цахилгаанчин, ахлагч
97. Оюунбатын Мөнхтулга - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн радиотелеграфчин, дэд ахлагч
98. Сайнбаярын Мөнх-Эрдэнэ - Хилийн цэргийн дээд сургуулийн дамжааны захирагч, дэслэгч
99. Даваагийн Мягмаржав - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн тасгийн пулемётчин, дэд ахлагч
100. Зоригийн Мягмарсүрэн - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ахлах радиотелеграфчин, дэд ахлагч
101. Насанжаргалын Мягмарсүрэн - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн гэрээт цэрэг, байлдагч
102. Оюунчимэгийн Наранбаатар - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн механик жолооч-сургагч, дэд ахлагч
103. Баттулгын Наранбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн артиллерийн тооцоочин, дэд ахлагч
104. Нацагдоржийн Нарангэрэл - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн гэрээт цэрэг, байлдагч
105. Буянжаргалын Нармандах - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нярав жолооч, дэд ахлагч
106. Бат-Эрдэнийн Наранхүү - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн артиллерийн батарейны холыг ээмгич, дэд ахлагч
107. Цэндсүрэнгийн Нүрээд - Хилийн цэргийн 0129 дүгээр заставын орлогч, дэслэгч
108. Арвинхүүгийн Нэргүй - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн тактикийн багш, төлөвлөгч дэд хурандаа
109. Дансрангийн Нэргүй - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатомётчины туслах-буудагч, дэд ахлагч
110. Гаваагийн Нямдаваа - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн инженерийн хадгалах тасгийн инженер, ахлах дэслэгч
111. Энэбишийн Нямдорж - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн нярав засварчин, ахлагч
112. Ичинноровын Нямсүрэн - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн авто техникийн хадгалах тасгийн инженер, дэслэгч
113. Сандагдоржийн Одонбаатар - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн станцын дарга, жолооч, ахлах ахлагч
114. Баярсайханы Одмөнх - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик оператор, дэд ахлагч
115. Бирваагийн Одхүү - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн тагнуулын хадгалах тасгийн дарга, ахлах дэслэгч
116. Доржийн Одхүү - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн радиотелеграфчин, дэд ахлагч
117. Лхагвын Одхүү - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
118. Шатарбалын Олдохбаяр - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн дайчилгааны нууцын хэрэг хөтөлөгч, дэд ахлагч
119. Сандагдоржийн Отгонсүх - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн гэрээт цэрэг, байлдагч
120. Любагийн Отгонбаатар - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн жолооч засварчин, дэд ахлагч
121. Сүхбаатарын Орхон - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик оператор, дэд ахлагч
122. Гунаажавын Очирбат - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн туслах программ зохиогч, цэргийн мэдээллийн мэргэжилтэн, ахлах дэслэгч
123. Очирбатын Очирсүрэн - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн зохион бүтээгч инженер, ахмад
124. Батмөнхийн Осор - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн танкийн механик жолооч, сургагч ахлагч
125. Даваанямын Отгонбаяр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик - жолооч, дэд ахлагч
126. Баянмонголын Отгонболд - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн жагсаалын дарга, ахлагч
127. Пүрэвийн Отгонтулга - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн тактик тусгай бэлтгэлийн багш, дэслэгч
128. Цэдэндоржийн Өлзийжаргал - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн цэрэг, цагдаагийн бүлгийн зохицуулагч ахлагч, дэд ахлагч
129. Сайжавын Пүрэвдорж - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн цахилгаан холбооны төвийн дарга, хошууч
130. Гомбын Пүрэвдорж - Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн поликлиникийн дарга, чих хамар хоолойн их эмч, дэд хурандаа

131. Баасанхүүгийн Пүрэв-Очир - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сансрын холбооны оператор, дэд ахлагч
132. Цэнджавын Ренчиндорж - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн жолооч радиотелеграфчин, дэд ахлагч
133. Бямбаагийн Сайнбилэг - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн дайчилгаа жагсаал ангийн тасгийн дарга, дайчилгааны ахлах офицер, дэд хурандаа
134. Зулын Санжаажав - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн ээлжийн дарга, ахлах ахлагч
135. Лхагвалпүрэвийн Сод-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
136. Цэрэндоржийн Сүх-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатомётчины туслах-буудагч, дэд ахлагч
137. Даргирийн Табарак - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн гранатомётчин, дэд ахлагч
138. Бат-Эрдэнийн Тайванжаргал - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик оператор, дэд ахлагч
139. Батбилэгийн Тогтохням - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сургуулийн төвийн танкийн талбайн оператор, дэд ахлагч
140. Цэндсүрэнгийн Төрмөнх - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн шатахууны нярав, дэд ахлагч
141. Батжаргалын Тулга - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн хөдөлгөөнт бүлгийн засварчин, дэд ахлагч
142. Батхүрэлийн Ууганбаатар - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн тасгийн пулемётчин, дэд ахлагч
143. Дашдондогийн Үүрцайх - Тагнуулын ерөнхий газрын ажилтан, ахлах дэслэгч
144. Чулуунбаатарын Үүрцайх - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатомётчин, дэд ахлагч
145. Сүхбаатарын Хаш-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн тасгийн пулемётчин, дэд ахлагч
146. Тогоонбаатарын Хишигдэлгэр - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатомётчины туслах-буудагч, дэд ахлагч
147. Дүгэрсүрэнгийн Хүрэлбаатар - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сумлагч, дэд ахлагч
148. Дашцэрэнгийн Хүрэлтулга - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн ахлах салёрчин тэслэгэчин, дэд ахлагч
149. Дашлхагвын Чинбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
150. Толягийн Чинбат - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн механик жолооч, дэд ахлагч
151. Ембүүгийн Цовоо - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн артиллерийн тагнуулын удирдах салааны тооцоочин, дэд ахлагч
152. Эрдэнэямбын Чулуундорж - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн гранатомётчин, дэд ахлагч
153. Отгонбаярын Цэлмэг - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн пулемётчин, ахлагч
154. Цэрэнгийн Шижир - Зэвсэгт хүчний 027 дугаар ангийн нярав-жижүүр, ахлагч
155. Нямын Шинэбаяр - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн радиотелеграфчин, дэд ахлагч
156. Батчулууны Энх-Амгалан - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн буудагч, дэд ахлагч
157. Батсүхийн Энхбаатар - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн тээврийн салааны жолооч, ахлагч
158. Наранбүрэнгийн Энхбаатар - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн салааны захирагчийн орлогч, ахлагч
159. Цоодолын Энхбаатар - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн засварын салааны захирагч, ахлах ахлагч
160. Батдэлгэрийн Энхбат - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн жолооч буудагч, дэд ахлагч
161. Дамдинсүрэнгийн Энхбат - Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн эрчимт эмчилгээ, мэдээгүйжүүлэлтийн их эмч, хошууч
162. Бямбаевын Энхбаяр - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн ротын захирагч, ахлах дэслэгч
163. Оюунгэрэлийн Энхболд - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн наводчик оператор, ахлагч
164. Бямбадоржийн Энхманлай - Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн наводчик оператор, дэд ахлагч
165. Рашжанчивын Энхтайван - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн инженер салёрын ротын механик жолооч, ахлагч
166. Мягмарын Энхтүвшин - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн радиотелеграфчин-жолооч, ахлах ахлагч
167. Доржийн Энхтүнх - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн буудлагын талбайн оператор, ахлах ахлагч
168. Оюуны Эрдэнэбаатар - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа
169. Шагдарын Эрдэнэбаатар - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн мэдээллийн аюулгүй байдлын мэргэжилтэн, хошууч
170. Очирхуягийн Эрдэнэбат - Зэвсэгт хүчний 311 дүгээр ангийн засварын тасгийн дарга, ахлах ахлагч
171. Магсарын Эрдэнэжаргал - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн жолооч, дэд ахлагч
172. Ванчинхүүгийн Эрдэнэхуяг - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн инженерийн засварын цехийн жолооч-засварчин, ахлагч

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛОГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

Суварга хайрхан уул, Хан хөхий уул, Сутай хайрхан уулыг төрийн тахилгатай болгох тухай

Монголчууд бидний өвөг дээдэс хүн байгалийн амин холбоо, харилцан шүтэлцээний утга учир, зүй тогтлыг сэтгэлгээний өндөр түвшинд ухааран мэдэрсний үндсэн дээр эх болсон байгалиа хайрлан хамгаалах, аргадан тайтгаруулах өвөрмөц соёл, арга ухааныг нүүдэлчдийн амьдралын хэв маяг, аж төрөх ёсноо нийцүүлэн хэрэгжүүлж ирсэн билээ. Түүхэн нэг тод жишээ бол уул овоогоо тахин шүтэж, аргадан биширч, хайрлан хамгаалж, төрийн болон орон нутгийн хэмжээнд тахилгын ёслолыг эртнээс нааш үйлдэж ирсэн монголчуудын заншил, уламжлал юм.

Монгол Улсад өдгөө хүрээлэн буй байгаль орчин, газар шороо, уул, устайгаа зүй зохистой, зөв харьцаж нөөц, баялгийг нь ариг гамтай ашиглан, унаган төрх, онгон далшин байдлыг нь хадгалан үлдээж хамгаалан өвлүүлэхэд төр засгийн болон иргэн бүрийн үүрэг, хариуцлага чухал болж буй нь улам бүр мэдрэгдэх боллоо.

Уул ус, газар нутгаа үе дамжин шүтэж, хайрлан хамгаалж ирсэн төрт ёс, ард түмнийхээ язгуурын уламжлалыг өртөөлүүлэн уул, овооны тэнгэрийг тайх төрийн тахилгын ёслолыг үйлдэх талаар ард иргэд, иргэний нийгэм, орон нутгийн төр

засгийн байгууллагуудаас ирүүлсэн санал, санаачлагыг харгалзан үзэж Монгол Улсын Үндсэн хуулийн 34 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БУУЛГАХ НЬ:

1. Суварга хайрхан уул, Хан хөхий уул, Сутай хайрхан уулыг төрийн тахилгатай уул болгож, уулын тэнгэрийг тайх төрийн ёслолыг 4 жилд нэг удаа үйлдсүгэй.

2. Энэхүү зарлиг буулгасантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2004 оны 57 тоот зарлигаар баталсан "Төрийн тахилгатай уул овооны тэнгэрийг тайх тахилгын ёслолын журам"-ын 1 дүгээр зүйлийн 1-дэх хэсэгт "Бурхан халдун уул" гэсний дараа "Суварга хайрхан уул, Хан хөхий уул, Сутай хайрхан уул" хэмээн нэмж оруулсугай.

3. Суварга хайрхан уул, Хан хөхий уул, Сутай хайрхан уулаа тахин шүтэж хайрлан хамгаалах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллахыг тус тусын нутгийн удирдлагын байгууллагуудад болон нийт иргэдэд уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

"Монгол Улсын Үндсэн хууль"-ийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь дэд хэсэгт заасан Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх, "Батлан хамгаалах тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх дэд хэсэгт заасан Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрхийг тус тус үндэслэн "Цэргийн цол олгох журам"-д өөрчлөлт оруулахын тулд ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлж "Цэргийн цол олгох журам"-ын "Цэргийн цол олгох" гэсэн 2 дахь хэсгийн 8 ба 9 дэх дэд хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ зарлиг гарсан өдрөөс хүчин төгөлдөр болно.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**
Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Маньбадрахын Ганболдод дээд офицерийн цол хүртээх тухай

Монгол Улсын "Үндсэн хууль"-ийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь дэд хэсэг, "Цэргийн цол олгох журам"-ын "Цэргийн цол олгох" гэсэн 2 дахь хэсгийн 14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цагдаагийн ерөнхий газрын дарга бөгөөд

Дотоодын цэргийн дарга, цагдаагийн хурандаа Маньбадрахын Ганболдод дээд офицерын "хошууч генерал" цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 186

Улаанбаатар хот

Цэдэвийн Сэргэлэнд дээд офицерийн цол хүртээх тухай

Монгол Улсын "Үндсэн хууль"-ийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь дэд хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн цэргийн штабын дарга, хурандаа Цэдэвийн

Сэргэлэнд дээд офицерын "бригадын генерал" цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 187

Улаанбаатар хот

Халидолдагийн Жекейд дээд офицерийн цол хүртээх тухай

Монгол Улсын "Үндсэн хууль"-ийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь дэд хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хил хамгаалах ерөнхий газрын дэд дарга

Халидолдагийн Жекейд дээд офицерын "бригадын генерал" цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 188

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.1, 58.1.2, 32 дугаар зүйлийн 32.4 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн өөрөө хүсэлт гаргасан тул Минжүүрийн Жаргалсайханыг Архангай аймгийн захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон тул Дарамын

Мягмаржавыг Дархан-Уул аймгийн шүүхийн шүүгчийн, Жагарын Байгалмааг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Буурхайн Баттөрийг Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Төмөрпүрэвийн Жаргалсайханыг Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Цогт-Очирын Отгонцэцэгийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Хумбаагийн Отгонжаргалыг Өвөрхангай аймгийн захиргааны хэргийн шүүхийн

шүүгчийн, Паньдийн Долгормааг Төв аймгийн шүүхийн шүүгчийн, Батнасангийн Батсүхийг Ховд аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Пунцагийн Цэцэгдуламыг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Жанчивсүрэнгийн Эрдэнэчимэгийг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн, Цэдэвийн Туяаг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн

шүүхийн шүүгчийн, бүрэн эрхийн хугацаа дууссан тул Дамдинсүрэнгийн Гансүхийг Төв аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 189

Улаанбаатар хот

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.5 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч Сайнцогтын Жаргал, Увс

аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Цэдэвийн Отгонжаргал нарыг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгож, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

Б.Нямсүрэнг шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн

Бүжинлхамын Нямсүрэнг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас огцруулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 07 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4 дахь хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Буурхайн Баттөрийг Баянхонгор аймгийн шүүхийн шүүгчийн, Төмөрлүрэвийн Жаргалсайханыг Говь-Алтай аймгийн шүүхийн шүүгчийн, Цогт-Очирын Отгонцэцэгийг Дундговь аймгийн шүүхийн шүүгчийн, Паньдийн Долгормааг Орхон аймгийн шүүхийн шүүгчийн, Лоолгойн Нямдоржийг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгчийн, Батнасангийн Батсүхийг Ховд аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Жагарын

Байгалмааг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, Жанчивсүрэнгийн Эрдэнэчимэгийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн, Цэдэвийн Туяа, Пунцагийн Цэцэгдулам нарыг Нийслэлийн Багануур дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Дарамын Мягмаржавыг Төв аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Хумбаагийн Отгонжаргалыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 46 дугаар зүйлийн 46.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. "Шүүхийн сахилгын хорооны дүрэм"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан

"Шүүхийн сахилгын хорооны дүрэм" батлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн 191 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Н.ЭНХБАЯР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2007 оны 192 дугаар зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхийн сахилгын хороо (цаашид "Сахилгын хороо" гэх) нь иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагаас шүүгчийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдол, хүсэлтийг хүлээн авч шалгах, сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, хариуцлага хүлээлгэх эсэхийг шийдвэрлэх эрх бүхий орон тооны бус байгууллага мөн.

1.2. Сахилгын хороо нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, бусад холбогдох хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэм болон энэхүү дүрмийг удирдлага болгон үйл ажиллагаагаа улсын хэмжээнд нэгдмэл байдлаар явуулна.

1.3. Сахилгын хорооны гишүүнд Шүүхийн тухай хуулийн 46-р зүйлийн 46.3-д заасан албан тушаалтан, байгууллага нэр дэвшүүлсэн саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл нэгтгэн, нэр дэвшигчийг төмилүүлэхээр нэр дэвшүүлсэн тогтоол, нэр дэвшигчдийн биеийн байцаалт, танилцуулгын хамт Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

1.4. Хэрэв Монгол Улсын Ерөнхийлөгч Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшүүлсэн хүнийг томилоогүй бол тухайн албан тушаалтан буюу байгууллага өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

1.5. Монгол Улсын Ерөнхийлөгч Сахилгын хорооны гишүүдийг томилсоноос хойш 14 хоногийн дотор Сахилгын хорооны даргад хорооны гишүүд дотроосоо нэр дэвшүүлж хуралдаанаараа хэлэлцэн нууцаар санал хурааж, олонхын санал авсан хүнийг төмилүүлэхээр Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Уг хуралдааныг Сахилгын хорооны хамгийн ахмад гишүүн удирдаж явуулна. Хэрэв Монгол Улсын Ерөнхийлөгч

Сахилгын хорооны даргад нэр дэвшүүлсэн хүнийг томилоогүй бол Сахилгын хороо өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

1.6. Сахилгын хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө орон гарвал Шүүхийн тухай хууль, энэ дүрэмд заасан журмын дагуу нөхөн томилно.

1.7. Сахилгын хорооны дарга, гишүүн Шүүхийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан эрхийг эдэлнэ. Сахилгын хорооны гишүүн дээрхээс гадна:

1.7.1. Гомдол, хүсэлтийг биечлэн шалгах;

1.7.2. Сахилгын хорооны даргын томилсноор сахилгын хэргийг хянан хэлэлцэх хуралдааныг даргалах эрхийг эдэлнэ.

1.8. Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан эсэхийг Сахилгын хорооноос өөр байгууллага, албан тушаалтан шалгаж шийдвэрлэхийг хориглоно.

Хоёр. Сахилгын хэрэг үүсгүүлэх тухай гомдол хүсэлтийг хүлээн авах, шалгах, сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах

1.2. Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн талаар иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан гомдол, түүнчлэн бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгчээс ирүүлсэн хүсэлтийг Сахилгын хорооны ажлын алба хүлээн авч:

2.2. Ажлын алба нь гомдол, хүсэлтийг бүртгэн, Сахилгын хорооны дарга, түүний зөвүйд орлож байгаа гишүүнд танилцуулна

2.3. Сахилгын хорооны дарга, түүний эзгүйд орлож байгаа гишүүн нь шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр ирүүлсэн гомдол, хүсэлтийг хянан шалгуулахаар Сахилгын хорооны аль нэг гишүүнд хуваарилна.

2.4. Сахилгын хорооны гишүүн дараах үндэслэл байвал гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагааг явуулж болохгүй:

2.4.1. Гомдол, хүсэлтийг өөрөө эсхүл түүний ажилладаг аж ахуйн нэгж, байгууллага гаргасан бол.

2.4.2. Тухайн шүүгчтэй эсхүл гомдол, хүсэлт гаргасан этгээдийн гэр бүлийн гишүүн төрөл, садан байвал.

2.4.3. Өөрөө шууд буюу шууд бусаар уг асуудалд хувийн сонирхолтой гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.

2.5. Сахилгын хорооны дарга, гишүүн тухайн гомдол, хүсэлтийг хүлээн аваад хянан шалгах ажиллагаа явуулах, эсхүл хариу өгөх, мөн харьяалалын дагуу өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

2.6. Сахилгын хорооны дарга, гишүүн гомдол, хүсэлтийг шалгуулахаар ажлын албанд удирдамж өгөх эрхтэй. Сахилгын хорооны гишүүний саналыг үндэслэн мөн хорооны даргын шийдвэрээр хянан шалгах ажиллагааг хэд хэдэн гишүүн, ажилтны бүрэлдэхүүнтэй явуулж болно.

2.7. Сахилгын хорооны гишүүн болон ажлын алба гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан хянан шалгана. Хэрэв нэмэлт ажиллагаа хийх шаардлагатай тохиолдолд Сахилгын хорооны дарга хугацааг нэг удаа 30 хүртэл хоногоор сунгана.

2.8. Ажлын алба, иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагаас нотлох баримт шаардан гаргуулах, тайлбар авах, шинжээч томилж дүгнэлт гаргуулах, хавтаст хэргээс хуулбар хийх, гомдол, хүсэлтийг болон сахилгын хэргийг тухайн шүүгчид танилцуулах, хариу тайлбар авах зэрэг хянан шалгах ажиллагаа хийсний дараа танилцуулга бичнэ.

2.9. Сахилгын хорооны дарга, гишүүн шалгалтын баримттай танилцан хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримт хангалттай бүрдсэн гэж үзвэл шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, үүсгээс татгалзах тухай захирамж гаргах, эсхүл тогтоосон хугацаанд нэмэлт шалгалт хийхийг ажлын албанд даалгана.

2.10. Ажлын алба шүүгчид сахилгын хэрэг үүсгэсэн, үүсгэхээс татгалзсан захирамжийг ёсчисны дараа гомдол, хүсэлт гаргагч болон шүүгчид 7 хоногийн дотор хүргүүлэх бөгөөд энэ

тухай (огноо, цаг, минуттай нь тэмдэглэсэн) баримтыг хэрэгт хавсаргана.

2.11. Сахилгын хорооны анхан шатны хуралдааны бүрэлдэхүүнийг Сахилгын хорооны дарга томилно. Бүрэлдэхүүнийг томилохдоо гишүүдийн хуралдаанд оролцсон тоог харгалзан, ээлж дарааллаар жигд оролцуулах журмыг баримтална. Бүрэлдэхүүнийг томилсон Сахилгын хорооны даргын захирамжид Сахилгын хорооны хуралдааныг хэзээ, хаана хийх, ямар асуудал хэлэлцэх, хуралдаанд бэлтгэх ажиллагаа зэргийг тусгана.

2.12. Ажлын алба Сахилгын хорооны даргын захирамжийг Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд хүргүүлж, сахилгын хэрэгт холбогдсон шүүгч, түүнчлэн гомдол, хүсэлт гаргасан этгээдэд хуралдааны товыг заавал мэдэгдэнэ.

2.13. Хуульд заасан төр, байгууллага, хувь хүний нууцыг хамгаалахаас бусад тохиолдолд Сахилгын хорооны хуралдааныг нээлттэй явуулна.

Гурав. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх

3.1. Сахилгын хэргийг анхан шатны журмаар 3 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд орсон аль нэг гишүүний эрх бүхий этгээд татгалзан гаргах тухай хүсэлт гаргавал тухайн гишүүнийг байлцуулахгүйгээр бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэнэ. Бүрэлдэхүүний санал тэнцэн тохиолдолд тухайн гишүүнийг татгалзан гаргана. Харин бүрэлдэхүүнээр нь буюу олонхийг татгалзан гаргах хүсэлт гаргавал уг асуудлыг Сахилгын хорооны дарга хянан үзэж, өөр бүрэлдэхүүн томилох эсэхийг шийдвэрлэнэ.

3.2. Сахилгын хэрэг үүсгэгдсэн шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээд хэргийн баримттай танилцах, хуулбар тэмдэглэл хийж авах, Сахилгын хорооны хуралдаанд биечлэн оролцох, өмгөөлөгч авах, амаар болон бичгээр тайлбар гаргах, нотлох баримт гаргаж өгөх, анхан шатны хуралдааны шийдвэрт давж заалдах гомдол гаргах эрхтэй.

3.3. Сахилгын хэрэг үүсгэгдсэн шүүгч хуралдаанд оролцох хүсэлтээ бичгээр гаргасан боловч өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай байсан, гадаадад албан томилолтоор явсан зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүрэлцэн ирээгүй бол хуралдааныг хойшлуулна. Харин Сахилгын хорооны хуралдааны товыг мэдэгдсэн атал, оролцох хүсэлтээ бичгээр ирүүлээгүй бол энэ тухай баримтыг хэрэгт хавсарган, сахилгын хэргийг уг шүүгчийн эзгүйд хэлэлцэн шийдвэрлэж болно.

3.4. Сахилгын хэрэг үүсгүүлэхээр гомдол, хүсэлт гаргасан этгээд сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх хуралдаанд оролцож болно. Харин тэрээр хуралдааны товгы мэдсэн атлаа ирээгүй явдал нь хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

3.5. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэж байгаа бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзвэл шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээд, түүнчлэн холбогдох бусад хүмүүсийг хуралдаанд оролцуулж болно.

3.6. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэх хуралдаан хэргийн талаар хийсэн шалгалтын тухай гишүүний илтгэснээр эхэлнэ. Уг ажиллагааны дараа сахилгын хэрэг үүсгэгдсэн шүүгчийн тайлбарыг сонсож, нэмэлт тайлбар, бусад холбогдох баримт байгаа эсэхийг болон гомдол, хүсэлт гаргасан этгээдээс тодруулна. Мөн гэрч шинжээчийн тайлбар, дүгнэлтийг сонсож, нотлох баримтыг шинжлэн судална.

3.7. Гишүүд илтгэгчээс болон хуралдаанд оролцож байгаа бусад этгээдэд асуулт тавьж хариулт авах, шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээдийн нэмэлт тайлбарыг сонссоны дараа бүрэлдэхүүн тогтоол гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно.

3.8. Зөвлөлдөх тасалгаанд Сахилгын хорооны гишүүд хэлэлцэж буй асуудлаар ил санал хурааж, олонхийн саналаар тогтоол гаргана. Гишүүн санал өгөхөөс татгалзах, түдгэлзэх эрхгүй. Эхлээд илтгэгч гишүүн саналаа хэлж, дараа нь оролцсон гишүүн, хамгийн сүүлд даргалагч гишүүн саналаа хэлэх зарчмаар санал хураалт явагдана. Зөвлөлдөх тасалгаанд гаргасан санал нууц байна.

3.9. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана,

3.9.1. Сахилгын шийтгэл оногдуулах;

3.9.2. Сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох;

3.9.3. Сахилгын хэрэг үүсгэхээс татгалзсан Сахилгын хорооны дарга, гишүүний эхирэмжийг хүчингүй болгож дахин шалгуулахаар буцаах;

3.9.4. Шүүгчид эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр холбогдох баримтыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илжүүлэх.

3.10. Сахилгын хорооны тогтоолын төслийг илтгэсэн гишүүн боловсруулах бөгөөд ажлын алба үүнд туслалцаа үзүүмнэ. Тогтоол нь удиртгал, тодорхойлох үндэслэл, тогтоох хэсэгтэй байна.

3.10.1. Удиртгал хэсэгт тогтоолыг хэзээ, хаана гаргасан, хэрэг хэлэлцсэн бүрэлдэхүүн болон хуралдааны нарийн бичгийн дарга, хуралдаанд оролцогчдыг нэрлэн заана.

3.10.2. Тодорхойлох хэсэгт гомдол, хүсэлтийн утга, шүүгчийн тайлбар, гэрч, шинжээчийн тайлбар, дүгнэлтийн агуулга, шалгалтын танилцуулга зэргийг тусгана.

3.10.3. Үндэслэл хэсэгт хэрэгт байгаа болон сахилгын хорооны хуралдаанаар хэлэлцэгдэж, хэргийг шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтын хууль зүйн болон бодит үндэслэл, түүний хуралдаанаас хэрхэн үнэлж байгаа тухай заана.

3.10.4. Тотоох хэсэгт хэргийг шийдвэрлэхэд баримталсан хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтыг тодорхой зааж, оногдуулсан шийтгэл, сахилгын хэрэг үүсгэсэн, үүсгэхээс татгалзсан захирамжийг хэвээр үлдээсэн, хүчингүй болгосон, давж заалдах гомдол гаргах журам зэргийг заана.

3.11. Хуралдаан даргалагч Сахилгын хорооны хуралдаанаас гарсан тогтоолын товч агуулгыг танилцуулаад хуралдаан хаасныг мэдэгдэнэ.

3.12. Тогтоолд сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн бүрэлдэхүүн гарын үсэг зурж ёсчлон, тэмдэг дарж баталгаажуулна.

3.13. Ажлын алба Сахилгын хорооны тогтоолыг гарсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор Шүүхийн ерөнхий зөвлөл, тухайн шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээдэд хүргүүлнэ.

3.14. Ажлын алба тогтоолыг эрх бүхий этгээдүүдэд гардуулан өгсөн тухай баримтыг үйлдэж, хэрэгт хавсаргах бөгөөд энэ нь давж заалдах хугацааг тоолох үндэслэл болно.

3.15. Сахилгын хороо сахилгын хэрэг нэг бүрийг тусад нь хэлэлцэнэ. Харин хэд хэдэн шүүгч хамтран зөрчил гаргасан тухай гомдол байгаа бол хэргийг нэгтгэн хянан хэлэлцэнэ.

3.16. Сахилгын хорооны тогтоол хүчин төгөлдөр болох хугацааг дараах байдлаар тооцно.

3.16.1. Сахилгын хорооны тогтоолыг эрх бүхий этгээд хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногийн дотор давж заалдах гомдол гаргаагүй бол гомдол гаргах хугацаа дууссан өдрийн дараагийн өдрөөс.

3.16.2. Хэрэв давж заалдах гомдол гаргасан бол Сахилгын хорооны тогтоолыг хэвээр үлдээсэн буюу өөрчилсөн тухай Сахилгын хорооны давж заалдах шатны хуралдааны магадлал гарсан өдрөөс.

3.17. Сахилгын хорооны хуралдааны тэмдэглэлийг тухайн хэргийг шалгасан ажлын албаны хянан шалгагч хөтөлж, тэмдэглэлд хуралдаан даргалагч болон тэмдэглэл хөтөлсөн ажилтан гарын үсэг зурж, тэмдэг дарна.

Дөрөв. Сахилгын хорооны шийдвэрт гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх

4.1. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хэлэлцэн гаргасан тогтоолыг тухайн шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээд эс зөвшөөрвөл Сахилгын хорооны тогтоолыг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдаанд давж заалдах гомдол гаргах эрхтэй.

4.2. Ажлын алба давж заалдах гомдлыг хүлээн авч бүртгэн Сахилгын хорооны даргад танилцуулна.

4.3. Сахилгын хорооны дарга давж заалдах гомдолтой танилцаж, Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдааны товгыг зарлана. Тов зарласан захирамжид хуралдаан хэзээ, хаана болох, ямар асуудлыг аль гишүүний илтгэснээр хэлэлцэх, хуралдааны бэлтгэл ажиллагааг хангах тухай тусгасан байна. Давж заалдах шатны хуралдааныг Сахилгын хорооны дарга, түүний эзгүйд томилогдсон гишүүн даргална.

4.4. Ажлын алба хуралдааны товгыг хуралдаан болохоос 7 хоногийн өмнө нийт гишүүд, тухайн шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээдэд мэдэгдэх үүрэгтэй.

4.5. Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдаанд тухайн шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээд биечлэн оролцох эрхтэй.

4.6. Сахилгын хороо давж заалдах гомдлыг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй ирцтэйгээр хэргийг хэлэлцэн, хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэж магадлал гаргана.

4.7. Сахилгын хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэх хуралдаан Сахилгын хорооны бүрэлдэхүүнийг болон ямар хэргийг хэний гомдлоор хянан хэлэлцэж байгаа тухай хуралдаан даргалагчийн зарласнаар эхэлж, илтгэгч гишүүний илтгэлийг сонсоно. Илтгэлийг сонссоны дараа гомдол, хүсэлтийн агуулга, түүнийг шалгасан баримтыг шинэчлэн судалж, сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцсэн Сахилгын хорооны тогтоолын агуулга, үндэслэл, шийдвэрлэсэн байдалтай танилцаж, хуралдаанд оролцож байгаа шүүгч, бусад оролцогчийн тайлбарыг сонсож,

бүрэлдэхүүн магадлал гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно.

4.8. Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдаанд гишүүдийн саналыг илээр хураана. Сахилгын хорооны хуралдаанд оролцож байгаа гишүүдийн олонх нь зөвшөөрсөн тохиолдолд саналыг нууцаар хурааж болно. Зөвлөлдөх тасалгаанд гаргасан санал нууц байна.

4.9. Зөвлөлдөх тасалгаанд хэлэлцэж буй асуудлаар гишүүдийн санал тэнцвэл анхан шатны хуралдааны шийдвэр хэвээр үлдэнэ.

4.10. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн гишүүд давж заалдах шатны Сахилгын хорооны хуралдаанд хэргийг илтгэж болохгүй.

4.11. Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдаанаас давж заалдах гомдлыг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

4.11.1. Давж заалдах гомдлыг хангахгүйгээр Сахилгын хорооны тогтоолыг хэвээр үлдээх

4.11.2. Анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах

4.11.3. Сахилгын хорооны анхан шатны хуралдааны тогтоолын зарим хэсгийг хүчингүй болгох, зарим заалтыг хэвээр үлдээх буюу нэмэлт, өөрчлөлт оруулах

4.11.4. Сахилгын хорооны тогтоолыг хүчингүй болгож, сахилгын хэргийг дахин шалгуулж шийдвэрлүүлэх

4.11.5. Сахилгын хорооны тогтоолыг хүчингүй болгож, сахилгын хэргийг анхан шатны хуралдаанаар дахин хэлэлцүүлэх

4.11.6. Сахилгын хорооны тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон шүүгчийг цагаатгах

4.12. Магадлалд хуралдаан даргалагч болон хэргийг илтгэсэн гишүүн гарын үсэг зурж ёсчлон, тэмдэг дарж баталгаажуулна. Магадлалыг энэ дүрмийн 3.13-т заасан хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөл, тухайн шүүгч болон гомдол, хүсэлт гаргасан этгээдэд хүргүүлнэ.

4.13. Сахилгын хэргийг давж заалдах шатны журмаар хянан хэлэлцсэн хуралдааны тэмдэглэлийг ажлын албаны хянан шалгагч хөтөлж, хуралдаан даргалагч, тэмдэглэл хөтөлсөн ажилтан гарын үсэг зурж, тэмдэг дарна.

4.14. Давж заалдах гомдлоор сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн Сахилгын хорооны нийт гишүүдийн хуралдааны магадлал эцсийн шийдвэр байна.

4.15. Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

4.16. Сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч энэ дүрмийн 4.15-д заасан хугацаанд сахилгын шийтгэл дахин хүлээсэн бол Сахилгын хороо түүнийг огцруулах саналаа Шүүхийн Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ. Уг саналыг Шүүхийн Ерөнхий зөвлөл хуралдаанаараа хэлэлцэн Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

4.17. Шүүгчийн гаргасан сахилгын зөрчлийг илрүүлсэнээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулахгүй.

Тав. Сахилгын хорооны ажлын алба

5.1. Сахилгын хороо нь орон тооны ажлын албатай байна. Сахилгын хорооны ажлын алба нь (цаашид "ажлын алба" гэх) түүний өдөр тутмын тасралтгүй хэвийн ажиллагааг хангаж, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн ажлын албанд харьяалагдан ажиллана.

5.2. Ажлын албаны орон тоог Шүүхийн Ерөнхий зөвлөл тогтооно.

5.3. Ажлын алба дараах эрх, үүрэгтэй.

5.3.1. Гомдол, хүсэлтийг хүлээн авч бүртгэх, харъяаллын бус гомдол, хүсэлтийг Сахилгын хорооны дарга, гишүүнд танилцуулсаны үндсэн дээр буцаах буюу харъяаллын дагуу шилжүүлэх

5.3.2. Сахилгын хорооны дарга, гишүүний даалгаснаар гомдол, хүсэлтийг хянан шалгах ажиллагаа явуулах

5.3.3. Сахилгын хорооны дарга, гишүүнд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, хэрэг, өргөдөл гомдлыг хадгалах

5.3.4. Сахилгын хорооны хэвийн үйл ажиллагаа, хуралдааны бэлтгэлийг хангах, шийдвэрийг баримтжуулах, сахилгын шийтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих

5.3.5. Аймаг, нийслэл, сум буюу сум дундын, дүүргийн болон аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүгч нарын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулиар тогтоосон хугацаанд авах, бүртгэх, хадгалах, шалгалтад ашиглах

5.3.6. Хууль тогтоомжид заасан бусад эрх

5.4. Ажлын албаны дарга, ажилтныг Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дарга Сахилгын хорооны даргатай зөвшилцөн томилж, чөлөөлнө.

5.5. Ажлын албаны дарга, ажилтны ажил үүргийн хуваарийг Сахилгын хорооны дарга тогтооно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

П.Бямбадоржийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 1, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.4 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн тэтгэвэр тогтоолох насанд хүрсэн тул

Пүрэвийн Бямбадоржийг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийг тус тус баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь.

Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Доржийн Байгаламаг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Володагийн Цэрэнрагчааг Дундговь аймгийн захиргааны хэргийн

шүүхийн шүүгчийн, Сүхээгийн Уранчимэгийг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Намдагсүрэнгийн Батчимэгийг Хэнтий аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 159

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого, Ерөнхийлөгчийн 2006 оны 1 дүгээр зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол хөөмий" хөтөлбөрийг 1 дүгээр хавсралтын ёсоор, хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд уялдуулан Зохицуулах хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. "Монгол хөөмий" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Н.Баяртсайханд

хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар ханган, дотоод, гадаадын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахыг Зохицуулах хорооны дарга бөгөөд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшинд тус тус даалгасугай.

3. "Монгол хөөмий" хөтөлбөрийг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД М.ЭНХБОЛД
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2007 оны 159 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"МОНГОЛ ХӨӨМИЙ" ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монголын ард түмний утга соёлын өвийн нэгэн төрөл болсон хөөмийлөх урлаг нь эртний өвөг дээдсийн дунд үүсч бий болсныг монголчууд эдүгээ хүртэл өвлөн уламжилсаар ирсэн.

Хөөмий нь эртний нүүдэлчдийн уламжлалт соёлын нэгэн хэв шинж мөн боловч хөгжмийн урлагийн айд багтахын хувьд харьцангуй сүүлийн үед хамаарах бөгөөд түүнийг тодорхойлох нэр томъёо олон хэлээр гарсан байна.

Хоолой болон бие махбодийн бусад эрхтний тусламжтайгаар давхар өнгөний эгшиглэгээг гаргадаг олон үндэстэн, угсаатан дэлхий дээр амьдардаг.

Одоо эрдэмтэд 15 орчим улс, үндэстэнд хөөмий, хөөмий төст урлаг хөгжиж байгааг тогтоогоод байна. Хөөмий нь эрдэмтэн, судлаачдын анхаарлыг татаж, судалгааны эх хэрэглэгдэхүүн болж байна. Хөөмийг хөгжим судлал, хэл шинжлэл, түүх, угсаатны зүй, авиан зүй, урлаг судлал, соёл судлал, анагаах ухаан, физик, гоо зүй зэрэг тодорхой шинжлэх ухааны салбарын чиглэл, арга зүйн үүднээс судлагдах эхлэл бий болжээ.

Судалгааг Франц Улс, Япон улс, АНУ, Англи, Нидерландын Вант Улс, ХБНГУ, ОХУ зэрэг техник, технологийн өндөр хөгжилтэй орнууд янз бүрийн арга замаар хийж байна.

Хөөмийн судалгааг сургалтын үйл ажиллагаатай хослуулж байгаа газарт хөөмий, хөөмий төст урлагийн ялгаа зааг, шинж чанар нь улам бүр тодорхой болж үр дүнд хүрч байна.

2001 онд монголын хөөмийчид нэгдэн "Монгол хөөмий" холбоо төрийн бус

байгууллага байгуулсан нь одоогийн байдлаар монголын 200 орчим, гадаадын 100 шахам хөөмийчийг нэгтгэн үйл ажиллагаа явуулж байна.

Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага "Монгол хөөмий" холбоотой хамтран хөөмийчдийн наадам, уралдаан, эрдэм шинжилгээний хурал, хөөмийчдийн уулзалт зэрэг арга хэмжээ зохион байгуулдаг уламжлал тогтож байна. Үүний үр дүнд хөөмий сонирхогчдын тоо нэмэгдэж, соёл, урлагийн арга хэмжээнд хөөмийг оролцуулах явдал өргөжиж байна.

Яруу өгүүлэхийн эгшиглэнт урлаг-давхац хөгөөр илэрхийлэгдсэн гайхамшиг болох уянгын хөөмий, хархираа хөөмий, тэдгээрийн өвөрмөц дэг жаяг, арга маягийг сурч эзэмших, судалж хөгжүүлэх зорилгоор өргөн хүрээтэй ажил зохион байгуулахыг холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаач, мэргэжлийн багш, сурган хүмүүжүүлэгч, урлаг, соёлын зүтгэлтнүүдэд үүрэг болгосон "Монгол хөөмийн урлагийг хөгжүүлэх тухай" Ерөнхийлөгчийн 2006 оны 1 дүгээр зарлиг гарсан болно.

Монгол Улс морин хуурын уламжлалт урлагийг 2003 онд Монгол ардын уртын дууг 2005 онд хүн төрөлхтний аман болон биет бус соёлын өвийн шилдэг дээжист өргөмжлөн тунхаглуулж, ЮНЕСКО-гийн батламж хүлээн авсан нь түүхэн чухал үйл явдал болсон юм.

Монгол хөөмийн урлагийг ойрын хугацаанд хүн төрөлхтний аман болон биет бус соёлын өвийн шилдэг дээжист өргөмжлөн тунхаглуулах зорилт тавьж байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

Монгол хөөмийн урлагийг судалж сурталчлах, хадгалж хамгаалах, уламжлан хөгжүүлснээр хөөмийн өвөрмөц дэг жаяг, арга маягийг сурч эзэмших, судалж хөгжүүлэх ажлыг соёл, урлагийн байгууллага, уран бүтээлч, ардын авьяастны дотор өрнүүлэн дэлгэрүүлж улмаар түүний үндэсний болон олон улсын түвшинд эзлэх байр суурийг бэхжүүлнэ.

2.2. Хөтөлбөрийн зорилтууд:

- 2.2.1. Монгол хөөмийн судалгаа явуулна;
- 2.2.2. Монгол хөөмийн сургалт зохион байгуулна;
- 2.2.3. Монгол хөөмийг сурталчилна;
- 2.2.4. Хөөмийчдийг тодруулан урамшуулж, алдаршуулна.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

3.1.1. Хөөмийлөх ур чадвар, уламжлалт урын санг өвлөн эзэмшсэн билиг авьяастан, хөөмийчдийг судлан тогтоох.

3.1.2. Монголын нутаг нутгийн хөөмийчдийн талаархи каталоги гаргах.

3.1.3. Хөөмийн урлагийн талаархи ойлголтыг албан бус, зайны болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах.

3.1.4. Хөөмийчдийн үзлэг болон хөөмийн уралдаан, наадам, үзэсгэлэн, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах.

3.1.5. Хөөмийн урлагийн талаархи Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан улс, аймаг, нийслэл, байгууллагын бүртгэл-мэдээлэл, аудио, видео сан бүрдүүлэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах.

3.1.6. Хөөмийчдийг тодруулах, тэдгээрт дэмжлэг тусалцаа үзүүлэх, алдаршуулах.

3.2. Хөөмийн судалгааг дараахь чиглэлээр явуулна:

3.2.1. Хөөмийн үүсэл гарвалын судалгаа;

3.2.2. Монголчуудын хөгжмийн соёл, оюуны сэтгэлгээнд хөөмийн гүйцэтгэсэн үүрэг, түүхэн ач холбогдол;

3.2.3. Хөөмийн тархалт болон нутаг, нутгийн хувилбарууд, тэдгээрийн харьцуулсан судалгаа, хөөмийлөх донж маяг, дэг сургууль, төрөл зүйл, хөөмийн хөгжим;

3.2.4. Хөөмийд зориулсан хөгжмийн бүтээл (аман болон зохиолын), хөөмий болон урлагийн бусад төрлүүдийн холбоо;

3.2.5. Хөөмийн сургалт, заах арга зүйн уламжлал, шинэчлэл,

3.2.6. Алдарт хөөмийчдийн түүх, шастир, урлах эрдмийн судалгаа;

3.2.7. Хөөмий болон монголчуудын хэв заншил, бэлгэдэл, зан үйл, төрт ёсны уламжлалын холбоо;

3.2.8. Хөрш зэргэлдээ улсын ард түмний аман болон биет бус соёлын өвд хөөмийн урлагийг үзүүлсэн нөлөө, харилцан хамаарал.

3.3. Хөөмийн урлагийн сурталчилгааг өргөжүүлэх талаар:

3.3.1. Хөөмийн уламжлалт урын сан болон нутаг, нутгийн хөөмийчдийн тухай хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах, хөөмийн теле, радио хичээл явуулах;

3.3.2. Хөөмийн урлагийн тухай танилцуулга (CD, DVD) гаргах;

3.3.3. Хөөмийн урлагийн тухай цуврал баримтат кино бүтээх;

3.3.4. Хөөмийчид болон хөөмийн уламжлалт урын санг сурвалжлан илрүүлэх, судлан сурталчлах, өвлүүлэн хөгжүүлэх, урамшуулан алдаршуулах зорилгоор төв, орон нутаг, олон улсын хэмжээнд хөөмийчдийн үзлэг болон хөөмийн уралдаан, наадам, уулзалт, ярилцлага, сургалтыг үе шаттай зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдаж, уялдуулан зохицуулах үүргийг Зохицуулах хороо гүйцэтгэнэ.

2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангах, мэдээллээр ханган хэрэгжилтэд нь хяналт тавих үүргийг боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ.

3. Орон нутагт "Монгол хөөмий" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохицуулах салбар хороог аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга байгуулан ажиллуулна. Салбар хорооны бүрэлдэхүүн, түүний ажлын чиг үүргийг Засаг дарга батлан гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллана.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

"Монгол хөөмий" хөтөлбөрийг 7 жилийн (2008-2014 он) хугацаанд хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт

"Монгол хөөмий" хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллага, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага (аймаг, нийслэл, мэргэжлийн эвлэл, холбоо, төв, студи зэрэг)-тай хамтран хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт санхүүжилт нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Улсын төсөв, Соёл, урлаг хөгжүүлэх сангийн хөрөнгө;

- Гадаад орон, олон улсын байгууллагын хандив, тусламж;

- Байгууллага, иргэдээс оруулсан хандив, тусламжийн хөрөнгө.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

1. Хөөмийн урлагийг өвлөсөн ардын билиг авъяастны үйл ажиллагааг дэмжих, тэдний авъяас билиг, арга барил, дэг сургуулийг хамгаалан, хөгжүүлэх ажлын шинэ тогтолцоо бүрдэнэ.

2. Хөөмийн урлагийн мартагдаж буй өв уламжлалыг сэргээн өвлөх, хөгжүүлэх үйл ажиллагааны түвшин дээшилж, хамрах хүрээ, далайц, хүртээмж нэмэгдэнэ.

3. Хөөмийн урлагийн судалгаа, сурталчилгаа эрчимжиж, суурь болон хавсарга судалгааны тоо, чанарт ахиц гарч уг чиглэлээр олон улсын болон улс, бус нутаг, орон нутгийн хэмжээнд зохиох арга хэмжээний менежмент боловсронгуй болно.

4. Улс, аймаг, нийслэл, холбогдох байгууллага хөөмийн бүртгэл-мэдээллийн сантай болж, сонирхогч, авъяастан, уран бүтээлчдийн эрэлт хэрэгцээг хангах, тэдэнд үйлчлэх материаллаг бааз болон оюуны орчин бий болно.

5. Хөөмийн урлаг сэргэж, монгол үндэстэн, угсаатан, монгол хүний соёлын хэрэглээ болж, төрт ёс, баяр наадмын нэгэн хэсэг болох орчин бүрэлдэж, олон улсын түвшинд хөөмийн урлагийн эзлэх байр суурь дээшилнэ.

Найм. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд

- "Монгол хөөмий" хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг бүх шатны Засаг дарга нар баталсан байх.

- Соёлын өвийн улсын нэгдсэн болон байгууллага, сум, аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн сан хөөмийн урлагийн талаархи бүртгэл-мэдээлэлтэй болсон байх.

- Аймаг, нийслэл, сум, дүүргээс хөөмийн албан болон албан бус сургалт явуулсан байдал.

- Хөөмийн урлаг сэргэж, мэргэжлийн урлагийн байгууллагууд хөөмийчтэй болсон байх.

- Хөөмийн урлагийн чиглэлээр зохион байгуулсан бус нутаг, улс, олон улсын уралдаан, наадмын менежментийн түвшин.

- Хөөмий сонирхогч, ардын авъяастан-хөөмийчдийн тоо өссөн байдал.

Засгийн газрын 2007 оны 159 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

"МОНГОЛ ХӨӨМИЙ" ХӨТӨЛБӨРИЙГ УЛСЫН ХЭМЖЭЭНД УЯЛДУУЛАН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Хөгжим, бүжгийн коллежийн захирал;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд.	-Аймгуудын Боловсрол, соёлын газрын дарга;
Гишүүд:	-Утга соёлын өвийн Үндэсний төвийн тэргүүн (тохиролцсоноор);
-ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комиссын Ерөнхий нарийн бичгийн дарга;	-“Монгол хөөмий” холбооны тэргүүн (тохиролцсоноор);
-Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;	Нарийн бичгийн дарга
-Үндэсний дуу, бүжгийн эрдмийн чуулгын дарга;	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн газрын утга соёлын өв, орон нутгийн бодлого, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн.
-Соёл, урлагийн их сургуулийн захирал;	
-Соёлын дээд сургуулийн захирал;	

Засгийн газрын 2007 оны 159 дүгээр
 тогтоолын 3 дугаар хавсралт

"МОНГОЛ ХӨӨМИЙ" ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРГЭЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эргэ хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Сэнхүүжилт (сая Т), эх үүсвэр	Сэнхүүжилтийг хэрэгждэх байгууллага	Арга хэмжээг зохион байгуулах байгууллага
1. Хөөмийн урлагийн судалгааны талаар				
1. Монгол хөөмий (уянган болон хархираа)-г хадгалж хамгаалах асуудлыг судлах үндэсний багийг томилон ажиллуулах	2007		Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Зохицуулах хороо
2. Үндэсний баг хээрийн шинжилгээ, судалгаа хийх 2 жилийн ажлын төлөвлөгөө, төсөв боловсруулж батлуулан хэрэгжүүлж ажиллах	2008-2009	6.0	Соёл, урлаг хөгжүүлэх сэн, Шинжлэх ухаан, технологийн сан, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	Монгол хөөмийг хадгалж хамгаалах асуудлыг судлах үндэсний баг
3. Хөөмийн-дийн каталоги гаргаж хэвлүүлэх	2007-2008	2.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухаан, технологийн сан	Монгол хөөмийг хадгалж хамгаалах асуудлыг судлах үндэсний баг, "Монгол хөөмий" холбоо
4. Монгол хөөмийг хадгалж хамгаалах асуудлыг судлах үндэсний багийн жил бүрийн ажлын тайлангийн болон эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж цаашдын зорилгыг тодорхойлох	2008 XII 2009 XII	2.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухаан, технологийн сан	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Зохицуулах хороо
5. Монгол угсаатны хөгжим, аман болон биег бус соёлын өвийн музей-судалгааны төв лаборатори байгуулж ажиллуулах	2008-2010	180.0 Аүнчй 110 сая нь гадаадын тусламж/	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухаан, технологийн сан	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Мэрин жуур, уртын луу, хөөмий, бий биеэлэг зэрэг ардын урлагийн төрөл зүйлийг хөгжүүлэх хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохион байгуулах зөвлөл, хороо болон энэ чиглэлээр хамтран ажиллах гадаадын байгууллагууд
6. Монгол хөөмийн судалгааны ном (CD, VCD-тэй) хэвлүүлэх	2009, 2012, 2015	3.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухаан, технологийн сан	Зохицуулах хороо, "Монгол хөөмий" холбоо

7.	Монгол хөсвийн өрсөлийг танилцуулга тохиожихол хэвлүүлэх	2008	12	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухааны, технологийн сан	Монгол хөсвийг хөдлөө
8.	Хөсвийн чиглэлээр өлсөн улсын хамтарсан судалгаа явуулах	2010-2011	11.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухааны, технологийн сан	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо
9.	"Хөсвийн урлаг" судалгааны хамтын бүтээл хэвлүүлэх	2012	15.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухааны, технологийн сан	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо
10.	Хөсвийн урлагийн талаар улс, аймаг, хөдөлгөөл байгууллагын бүртгэл мэдээллийн санг бүрдүүлж, жил тутам баяжуулан ажиллах	2008-2014	7.0	Утга соёлын өвийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, аймгийн даргын газар, сумын соёлын төв	Утга соёлын өвийн үндэсний төв, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, аймгийн даргын газар, сумын соёлын төв
2. Хөсвийн урлагийн сургалт, сурталчилгааны талаар					
1.	Монгол хөсвийн хөтөлбөрийн агуулга, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлбэрлэх байгууллага, ажлантуудын дүнд сургалт-семинар зохион байгуулах	2008	2.5	Соёл, урлаг хөгжүүлэх сан	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо
2.	Аймаг, нийслэл хөтөлбөрийн хэрэгжилтийн тавилан жил бүр гаргаж, хяналт шинжилгээ үндсээ хийн Зохицуулах хороонд мэдээлэх	2008-2014	-	Тухайн сургуулиуд	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газар
3.	Судалгаа хийсний үндсэн дээр боловцоотой аарим сургуульд, хөсвийн албан болон албан бус сургалт явуулах	2008-2014	-	Тухайн сургуулиуд	Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын газар, сургуулийн захиргаад
4.	Монголын хөсвийнчдийн анхдугаар чуулга уулзалт, нээгдэж зохион байгуулах	2008	6.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо
5.	Монгол Улсын хэмжээнд хөсвийн нөөцгүйг бүрчилэн аажим байгуулах	2009, 2012	10.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Зохицуулах хороо, аймгуудын Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёлын газар

6.	Олон улсын хөөмийчдийн наадмыг Улаанбаатар хотод зохион байгуулах	2009, 2012	61.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо, "Монгол хөөмий" холбоо
7.	Монгол хөөмийн тухай цуврал баримтат кино бүтээх	2008-2014	14.0	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Шинжлэх ухаан, Технологийн сан	Зохицуулах хороо, "Монгол кино" нэгтгэл, "Соёл Эрдэнэ" студи
3. Хөөмийн урлагийг хадгалж хамгаалах, хөөмийчдийг тодруулан алдаршуулах талд					
1.	Монгол хөөмийг хүн төрөлхтний амьтан болон биет бус соёлын өвийн шилдэг дээжид ергэмжлэн тунхаглуулах талаар ЮНЕСКО-д уламжлах	2008-2009	8.0	ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс, Утга соёлын өвийн үндэсний төв
2.	Нийслэл, аймаг бүр хөөмийн урлагийг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2008-2014	Улсын төсөв, хандив, тусламж		Нийслэл, дүүрэг, аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, соёл, боловсролын байгууллага
3.	Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр хөөмий сонирхогч авьяаснуудаа тодруулж, тэдэнд дэмжлэг үзүүлж ажиллах	2008-2014	Өөрийн төсөв	Нийслэл, дүүрэг, аймаг, сум	Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёлын болон Соёл, урлагийн газар
4.	"Монгол хөөмий" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд амжилт гаргасан байгууллагыг 2 жил тутам шалгаруулан шагнах уралдааны болон боловсруулж Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар батлуулан амжиллах	2009		Соёл, урлаг хөгжүүлэх сан, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо "Монгол хөөмий" холбоо
5.	Монгол хөөмийн ховор, хосгүй өвийг хадгалж хамгаалах, сурталчлахад амжилт гаргасан ардын авьяастан, уран бүтээлчийг хөхиүлэн дэмжиж шагнах журам боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаар батлуулан ажиллах	2009	Тухайн журмын дагуу	Соёл, урлаг хөгжүүлэх сан, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Зохицуулах хороо, "Монгол хөөмий" холбоо
6.	Олон улсын хөөмийн наадам, уралдаан, тэмцэнд Монголын хөөмийчдийг оролцуулах	2008-2014			Зохицуулах хороо, "Монгол хөөмий" холбоо

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 06 дугаар сарын 26-ны өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь: Ардын хувьсгалын 86 жилийн ойг тохиолдуулан дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын Засгийн газрын Хүндэт өргөмжлөлөөр шагнасуугай:

1. Цэрэнлхамын Манлажав - Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

2. Самдангийн Алтангэрэл - Улсын гаалийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга;

3. Альхавын Сауле - Байгаль орчны яамны Ойн бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн;

4. Дөчийн Дангаа - Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын зөвлөх эмч;

5. Дорждэрэмийн Ганхуяг - Зэвсэгт хүчний жанжин штабын Энхийг дэмжих хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн;

6. Борнойн Амарсайхан - Үйлдвэр, худалдааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын мэргэжилтэн;

7. Галсанжамцын Лосол - Барилга, хот байгуулалтын яамны Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлого зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн;

8. Шаравын Батрэнчин - Түлш, эрчим хүчний яамны Түлш, эрчим хүчний бодлого, стратеги төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн;

9. Баатаржамцын Гантулга - Гадаад хэргийн яамны Гадаад хэргийн төв архивын дарга.

10. Дүлзэнгийн Батмөнх - Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны дэд ерөнхийлөгч;

11. Хайдавын Бадам - Улсын мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны улсын байцаагч;

12. Оргийн Цэрэндэмбэрэл - Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн эрхлэгч;

13. Галбадрахын Гантөмөр - Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга;

14. Нямын Аюуш - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Мэдээлэл, судалгаа, үнэлгээний газрын дарга;

15. Раднаагийн Бандий - Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны "Боловсролын хөгжлийн хөтөлбөр"-ийн албаны гүйцэтгэх захирал;

16. Маадайн Сандаг-Очир - Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын ахлах референт;

17. Жигжидийн Мөнхбат - Их шавийн дээд сургуулийн захирал;

18. Төмөрийн Дашням - Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын дарга.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА

С.БАТБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар сарын 04-ний өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

"Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал" сэдэвт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай

Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги"-ийн 4.2-т дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс Шведийн төрийн захиргааны олон улсын хөгжлийн институттэй хамтран 2006-2009 онуудад хэрэгжүүлж байгаа "Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал" сэдэвт сургалтын хөтөлбөрт

эрхлэх асуудлынхаа хүрээнд үйл ажиллагаа эрхэлж байгаа төсвийн байгууллагын ерөнхий менежерүүдийг хамруулан суралцуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. "Суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал" сэдэвт сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр Засгийн газарт танилцуулж

байхыг Төрийн албаны зөвлөл (Ж.НОРОВСАМБУУ)-д зөвлөсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА** **С.БАТБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 169

Улаанбаатар
хот

Тогтоолын заалт хүчингүй
болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

хүчингүй болсонд тооцсугай.

нь:

"Журам батлах, төлбөрийн хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 2002 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 177 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД** **Ц.ЦЭНГЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 170

Улаанбаатар
хот

Зарим албан тушаалын цалингийн
жишгийг шинэчлэн тогтоох тухай

Төрийн албаны тухай хуулийн 28.6-г үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг дор дурдсанаар шинэчлэн тогтоож, 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг 2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Дүүргийн Засаг дарга 192254 - 226730

Сумын Засаг дарга 178870 - 212737

Хорооны Засаг дарга 144799 - 171974

Бэгийн Засаг дарга 125736 - 151492

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

САНГИЙН САЙД **Н.БАЯРТСАЙХАН**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар
сарын 10-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар
хот

Хөдөлмөрийн хөлсний доод
хэмжээг шинэчлэн тогтоох тухай

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 7 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтны болон иргэд хоорондын хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг



2007 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нэг цагт 474 төгрөг 38 мөнгө буюу сард 80000 (наян мянган) төгрөг байхаар шинэчлэн тогтоосугай.

10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолыг 2007 оны

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

САНГИЙН САЙД **Н.БАЯРТСАЙХАН**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 177

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

энэ ажлыг эрхэлж байсан байгууллага, компаниудтай..." гэж өөрчилсүгэй.

"Төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд байгуулах тухай" Засгийн газрын 2007 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 36 дугаар тогтоолын "... одоо энэ ажлыг эрхэлж байгаа компанитай..." гэснийг "...

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД** **Д.ДЭМБЭРЭЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар сарын 18-ны өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 8.3, Монголын морин спорт, уяачдын холбооны саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хархоринд, ..." гэснийг "Өвөрхангай аймгийн Арвайхээрт, ..." гэж өөрчилсүгэй.

"Хурдан морины шигшмэл болон бүсийн уралдааны 2007 оны хуваарийг тогтоох тухай" Засгийн газрын 2007 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 30 дугаар тогтоолын "... Өвөрхангай аймгийн

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **М.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ДАРГА** **С.БАТБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 07 дугаар сарын 25-ны өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Зардлын дундаж норматив батлах тухай

Боловсролын тухай хуулийн 40.2, 40.3, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 25.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

боловсролын сургуулийн нэг суралцагчид бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 2 дугаар, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн анхан шатны ангийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталж 2007 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдсүгэй.

1. Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 1 дүгээр, ерөнхий

2. Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 62900 (жаран хоёр мянга есөн зуун) төгрөгөөр, үүнээс цалингийн хувьсах зардлын дундаж нормативыг 46700 (дөчин зургаан мянга долоон зуун) төгрөгөөр, бусад хувьсах зардлын дундаж нормативыг 16200 (арван зургаан мянга хоёр зуун) төгрөгөөр тус тус баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Зардлын дундаж норматив батлах тухай" Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 167 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД** **Ө.ЭНХТҮВШИН**

Засгийн газрын 2007 оны 184 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НЭГ ХҮҮХДЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ

(мян. төг)

№	Байршил	Цалин зардал	Бусад хувьсах зардал
1	Аймгийн төвөөс бусад сумын	259,7	37,1
2	Аймгийн төвийн	217,3	29,7
3	Нийслэлийн	210,1	26,5

Засгийн газрын 2007 оны 184 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН НЭГ СУРАЛЦАГЧИД БАГА, ДУНД БОЛОВСРОЛ ЭЗЭМШҮҮЛЭХЭД НОГДОХ ХУВЬСАХ ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ

(мян. төг)

№	Байршил	Сургуулийн ангилал	Багшийн цалингийн зардлын норматив			Сургалтын үйл ажиллагааны бусад хувьсах зардлын норматив		
			Бага анги	Дунд анги	Ахлах анги	Бага анги	Дунд анги	Ахлах анги
1	Аймгийн төвөөс бусад сумын	Багийн бага сургууль	181,3			40,8		
		Суурь боловсролын сургууль	86,9	124,5		16,1	23,1	
		Бүрэн дунд боловсролын сургууль	84,2	119,3	125,2	13,1	18,5	19,6
2	Аймгийн төвийн сумын болон түүнтэй дүйцэхүйц хүн амтай сумын, Нийслэлийн захын дүүргийн	Бага сургууль	84,2			13,1		
		Суурь боловсролын сургууль	80,3	113,8		11,4	16,1	
		Бүрэн дунд боловсролын сургууль	80,3	113,8	119,5	11,4	16,1	17,0
3	Нийслэлийн	Бага сургууль	80,3			11,4		
		Суурь боловсролын сургууль	77,1	105,9		11,1	14,3	
		Бүрэн дунд боловсролын сургууль	77,1	105,9	111,2	11,1	14,3	16,1

Засгийн газрын 2007 оны 184 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

**МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ-ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН
АНХАН ШАТНЫ АНГИЙН НЭГ СУРАЛЦАГЧИД НОГДОХ ХУВЬСАХ
ЗАРДЛЫН ДУНДАЖ НОРМАТИВ**

/мян.төг/

№	Аймаг	Норматив
1	Архангай	290,7
2	Баян-Өлгий	303,5
3	Баянхонгор	291,4
4	Булган	290,0
5	Говь-Алтай	302,8
6	Дорноговь	292,1
7	Дорнод	298,2
8	Дундговь	290,2
9	Завхан	302,4
10	Өвөрхангай	289,8
11	Өмнөговь	291,5
12	Сүхбаатар	295,2
13	Сэлэнгэ	291,1
14	Төв	289,4
15	Увс	302,7
16	Ховд	300,9
17	Хөвсгөл	290,7
18	Хэнтий	295,7
19	Дархан-Уул	289,5
20	Орхон	294,4
21	Говьсүмбэр	291,5
22	Улаанбаатар	289,9

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

 2007 оны 08 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 189

 Улаанбаатар
хот

Нэрэмжит болгох тухай

Холбогдох байгууллагын саналыг үндэслэн
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Завхан аймгийн Цэцэн-Уул сумын бүрэн дунд сургуулийг Монгол Улсын хөдөлмөрийн баатар, гавъяат багш Дорлигийн Дагвын;
2. Архангай аймгийн Хөгжимт драмын театрыг Монгол Улсын ардын жүжигчин Дашээгвийн Ичинхорлоогийн;
3. Архангай аймгийн Тариат сумын Соёлын төвийг Төрийн хошой шагналт, ардын жүжигчин Цэгмидийн Намсрайжавын;
4. Хөдөө аж ахуйн их сургуулийн Мал эмнэлгийн хүрээлэнг Монгол Улсын Төрийн шагналт, академич Цэвэгийн Тойвоогийн;
5. Сүхбаатар аймгийн Наран сумын дунд сургуулийг Төрийн шагналт яруу найрагч Очирбатын Дашбалбарын;

6. Говь-Алтай аймгийн Халиун сумын дунд сургуулийг төр, нийгмийн зүтгэлтэн Шагалын Жадамбаагийн;

7. Дорнод аймгийн Чулуунхороот сумын бүрэн дунд сургуулийг яруу найрагч Данзангийн Нямсүрэнгийн;

8. Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 5 дугаар бүрэн дунд сургуулийг Бүгд Найрамдах Турк Улсын анхны Ерөнхийлөгч Мустафа Кемал Ататуркийн нэрэмжит тус тус болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Ө.ЭНХТҮВШИН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 08 дугаар сарын 02-ны өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Байнгын төлөөлөгчийг томилох, эгүүлэн татах тухай

Засгийн газрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Томилолтын хугацаа дууссантай холбогдуулан Чойсүрэнгийн Баатарыг Монгол Улсаас Нью-Йорк дахь НҮБ-ын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

1. Очирын Энхцэцгийг Монгол Улсаас Нью-Йорк дахь НҮБ-ын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ГАДААД ХЭРГИЙН САЙД

Н.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

Цагаан зээрийн эвэр, халиун бугын ясан эвэр гадаадад гаргахыг хориглох тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2. Ан агнуурын тухай хуулийн 8.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Тусгай зориулалтаар гадаадын иргэнд агнуулсан цагаан зээрийн дагатай эвэрт энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлийг хамааруулахгүй байсугай.

1. Цагаан зээр, халиун бугын тархац нутаг хумигдан, тоо толгой цөөрсөнтэй холбогдуулан тэдгээрийн нөөцийг хамгаалах, цаг агаарын хуурайшилтай үед ой, хээрийн түймэр болон байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эврээр дотооддоо бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цагаан зээрийн эвэр, халиун бугын ясан эврийг гадаадад гаргахыг 2 жилийн хугацаагаар хориглосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Монгол Улсын сайд У.Хүрэлсүх, Улсын гаалийн ерөнхий газрын дарга Д.Баттөмөр нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар хот

Монголын бүх ард түмний спортын XII их наадам зохион байгуулах тухай

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5, 16.1-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

санхүүжүүлэхийг Сангийн сайд Н.Баяртсайхан, Эрүүл мэндийн сайд Д.Туяа нарт тус тус үүрэг болгосугай.

1. Монголын бүх ард түмний спортын ХП их наадмыг 2008 онд орон даяар зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд Д.Туяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Монголын бүх ард түмний спортын ХП их наадмыг зохион байгуулсан дүнг 2008 оны Ш улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Туяад даалгасугай.

2. Их наадмын анхан шатны уралдаан, тэмцээний зардлыг төсвийн багцад тусгахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт, шигшээ уралдаан, тэмцээний зардлыг Эрүүл мэндийн сайдын 2008 оны төсвийн багцад тусган

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Д.ТУЯА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 08 дугаар сарын 08-ны өдөр

Дугаар 195

Улаанбаатар хот

Хэлэлцээр батлах тухай

Олон улсын гэрээний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр-ийг баталсугай.

2007 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Худалдааны далайн тээврийн салбарт хамтран ажиллах тухай

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

М.ЭНХБОЛД

**ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Ц.ЦЭНГЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 08 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Улсын нэгдсэн үзлэг, шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

албан тушаалтныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалгаж, буруутай этгээдэд хариуцлага тооцон, гарсан хохирлыг нөхөн төлүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр, Тагнуулын ерөнхий газрын дарга Н.Ганболд нарт үүрэг болгосугай.

1. Химийн хорт болон аюултай бодисыг нэтрүүлэхээр зөвшөөрөгдсөн хилийн боомтыг шаардагдах лабораторийн болон хяналтын тоног төхөөрөмж, боловсон хүчнээр хангах, хилийн мэргэжлийн хяналтын болон гаалийн байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулан ажиллахыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Н.Баярсайхан нарт үүрэг болгосугай.

4. Захиргааны журмаар хураагдсан 145 тээрмийг "Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах ажлыг зохицуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 131 дүгээр тогтоолын дагуу улсын орлого болгох буюу устгах ажлыг 2007 оны 9 дүгээр сард багтаан зохион байгуулахыг аймгийн Засаг дарга нарт, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд У.Хүрэлсүх, Хууль зүй, дотоод хэргийн сайд Д.Одбаяр нарт үүрэг болгосугай.

2. Үйлдвэрлэлийн нөөц нь экологи, эдийн засгийн үнэлгээгээр үр ашиггүй болох нь тогтоогдсон алтны орд газарт болон нөхөн сэргээлт хийсэн талбайд шинээр ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохгүй байх, олгосон зөвшөөрлийг сунгахгүйгээр нөхөн сэргээлт хийлгэн хүлээн авахыг Үйлдвэр, худалдааны сайд Ц.Даваадоржид үүрэг болгосугай.

5. Химийн хорт бодисоор бохирдсон хөрс, ус, агаарт хийгдэх хяналт-шинжилгээг тогтмолжуулж, холбогдох зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд У.Хүрэлсүхэд даалгасугай.

3. Химийн хорт болон аюултай бодисыг хилийн боомтгүй газраар болон зөвшөөрөлгүй боомтоор нэвтрүүлж байгаа эсэхэд хяналт тавих, мөнгөн ус, цианидын хууль бус импорт, худалдааны сүлжээг илрүүлж, таслан зогсоох, улсын үзлэгээр байгаль орчин, хүн, малын эрүүл мэндэд хохирол учруулсан нь тогтоогдсон аж ахуйн нэгж, иргэн,

6. Мөнгөн ус, цианидаар хордсон хүмүүсийн судалгааг гаргаж, тэлгээрийг эмчлэх, эрүүлжүүлэх.

шаардагддаг эм, бэлдмэлийн нөөцийг бий болгох, мөнгөн усны хор нөлөөллийн талаар ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн сайд Д.Туяад үүрэг болгосугай.

7. Химийн хорт болон аюултай бодисыг шинжлэх лабораториудыг төрөлжүүлж, тэдгээрийн чадавхийг сайжруулах ажлыг зохион байгуулахыг Байгаль орчны сайд, Химийн хортой болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн дарга И.Эрдэнэбаатарт даалгасугай.

8. Хөрс, ус, үндны ус, агаарын чанарын улсын стандартуудыг шинэчлэх, боловсруулж батлуулах арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, холбогдох стандартыг баталж мөрдүүлэхийг Стандартчилал, хэмжил зүйн төвийн дарга Г.Гантөмөр нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН
САЙД

У.ХҮРЭЛСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 212

Улаанбаатар
хот

Хэлэлцээр батлах
тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ
нь:

Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг
баталсугай.

2006 оны 12 дугаар сарын 15-ны өдөр
Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан "Цэргийн
салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын
Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

М.СОНОМПИЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2007 оны 08 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 213

Улаанбаатар
хот

Хэлэлцээр батлах
тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ
нь:

Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг
баталсугай.

2006 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр Бүгд
Найрамдах Болгар Улсын Софи хотноо гарын үсэг
зурсан "Холбооны хэрэгсэл болон салбэг, эд анги
буцалтгүй тусламжаар олгох тухай Монгол Улсын
Засгийн газар, Бүгд Найрамдах Болгар Улсын

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД

М.СОНОМПИЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
И-мэйл: 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 3/5